**МОНГОЛ УЛС**
**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 10 өдөр　　　　　　Дугаар А/09　　　　　　Номгон

Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, эрэмбэлэх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.3, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, эрэмбэлэх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

| | |
|---|---|
| Г.Энхбаяр | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч |

Гишүүд:

| | |
|---|---|
| С.Байгалмаа | Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга |
| Т.Эрдэнэбат | Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| В.Наранчимэг | Нийгмийн бодлогын хэлтсийн дарга |
| Д.Алтангэрэл | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга |
| Э.Ганзориг | Байгаль орчны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| У.Балжинням | Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| Т.Норовринчин | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн |
| Б.Ичинхорлоо | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн |
| Ч.Дуламсүрэн | Баянхонгор аймгийн 10 дугаар багийн иргэн /Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл/ |

625010017

Нарийн бичгийн дарга:

| | |
|---|---|
| З.Мөнхтөр | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ажилтан |

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, эрэмбэлэх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах ажлын хэсгийн тайланг 06 дугаар сарын 25-ны дотор танилцуулахыг ажлын хэсэг (Г.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН